



АТАР-ӨРГӨӨ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

20 26 оны 02 сарын 16 өдөр

№ 26/03

Улаанбаатар хот

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХГҮЙ БАЙХААР ШИЙДВЭРЛЭСЭН ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5, 46.7, 46.8 дахь заалтууд, “Атар-Өргөө” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Эдийн засгийн хямрал, түүхий эд материалын үнийн өсөлт, мөн зарим хуучирсан тоног төхөөрөмжүүдээ шинэчлэх, олон жилийн насжилттай барилга байгууламж, шугам хоолойн засвар үйлчилгээ хийх шаардлагатай байгаа тул “Атар өргөө” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд 2026 онд ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсүгэй.

2. Ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, түүний үндэслэлийн талаар компанийн 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.

3. Ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ХК-д тус тус хүргүүлэх, ногдол ашиг тараахгүй тухай мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-д тус тус танилцуулахыг Гүйцэтгэх захирал (Ж.Сайнбилэг), Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Д.Долзодмаа) нарт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ДАРГА



Б.МӨНХДАЛАЙ